

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2018 оны 4-р сарын 25-ны байдлаар


2018 оны 4-р сарын 25-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 6.8 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.6 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2018 оны 4-р сарын 25-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 14.3 хувь, үхрийн ястай махны үнэ 10.3 хувь, үхрийн цул махны үнэ 11.2 хувь, адууны ястай махны үнэ 7.6 хувь, ямааны махны үнэ 6.7 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 1.4 хувиар өссөн бол бусад махны үнэ өөрчлөлтгүй байна.

2018 оны 4-р сарын 25-ний байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7465 төгрөг, үхрийн /ястай/ мах 8525 төгрөг, үхрийн цул мах 10320 төгрөг, адууны /ястай/ мах 6075 төгрөг, ямааны /ястай/ мах 5000 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ




Гурилын үнэ: 2018 оны 4-р сарын 25-ны байдлаар савласан дээд гурилын үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногтой харьцуулахад 1-р зэргийн задгай гурилын үнэ 0.9 хувиар буурсан бол бусад гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2018 оны 4-р сарын 25-ний байдлаар цагаан будааны үнэ өмнөх сараас 2.6 хувь, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 1.8 хувиар өссөн байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх сараас 1.1 хувиар өссөн бол өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна. (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2018 оны 4-р сарын 25-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 6.4 хувь, хүрэн манжингийн үнэ 23.0 хувь, луувангийн үнэ 19.5 хувь, байцааны үнэ 10.9 хувь, сонгины үнэ 4.6 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногийнхоос төмсний үнэ 0.5 хувиар өссөн бол бусад хүнсний ногооны өөрчлөлтгүй байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2018 оны 4-р сарын 25-ны байдлаар сүүний үнийг өмнөх сарынхтай харьцуулахад савласан /1 литрийн/ сүүний үнэ 1.4 хувь, “элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 1.7 хувиар өссөн бол задгай сүүний үнэ өөрчлөлтгүй байлаа. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.6 хувиар буурч, бусад сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байгаа бол цөцгийн тосны үнэ өмнөх сараас 4.9 хувь, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байлаа.